

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Авто зам засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн Говь-Алтай аймаг дахь салбарын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/003/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот	2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор: Э.Сүнжидмаа утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn
--	---------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2026/003/НА-СТА-ТӨҮГ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.03.12 № 127

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Авто зам засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК-ийн Говь-Алтай аймаг дахь салбарын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 220 дугаар тогтоолоор авто замын засвар, арчлалтын ажил эрхлэлдэг 20 компанийг нэгтгэн "Авто зам засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК болгон өөрчилж зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төв компаниас санхүүжилтийг 485,590.9 мянган төгрөгөөр дутуу олгож, 46,009.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Тус салбар нь 559,382.5 мянган төгрөгийн авлагатай, 347,688.8 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд "Авто зам засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК-аас 2025 онд засвар арчлалтын гэрээ болон авто зам хариуцагчийн гэрээ байгуулаагүй байна.

АВТО ЗАМ ЗАСВАР АРЧЛАЛТЫН
НЭГТГЭЛ ТӨХК-ИЙН ГОВЬ-АЛТАЙ
АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН МЕНЕЖЕР
В.СҮРРАГЧАА ТАНАА

822511000387

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>366,200,474.26</u>	<u>716,255,004.94</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	352,149,547.42	36,088,353.26
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	870,297.56	-
31110	Төгрөг	870,297.56	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	260,199,330.27	36,088,353.26
31213	Арилжааны банк дахь харилцах	260,199,330.27	36,088,353.26
33	АВЛАГА	14,050,926.84	559,382,527.12
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	971,857.50	
33401	Дансны авлага /ТӨҮГ/	9,880,000.00	73,550,568.02
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	3,199,069.34	241,060.40
335	Бусад авлага		485,590,898.70
3351	Байгууллагаас авах авлага		485,590,898.70
35	БАРАА МАТЕРИАЛ	91,079,919.59	120,784,124.56
351	Түүхий эд материал	29,960,968.20	41,545,454.36
35300	Бэлэн бүтээгдэхүүн	29,960,968.20	41,545,454.36
354	Хангамжийн материал	61,118,951.39	79,238,670.20
35470	Бусад хангамжийн материал	61,118,951.39	79,238,670.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>852,324,354.80</u>	<u>755,918,526.46</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	497,084,354.80	401,278,526.46
392	Биет хөрөнгө	497,084,354.80	401,278,526.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	103,200,161.09	121,291,070.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	(55,567,930.46)	(65,143,558.82)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,083,842,416.14	1,083,842,416.14
39204	Хуримтлагдсан элэгдэл	(884,784,460.09)	(948,612,807.47)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	487,129,132.54	502,037,314.32
39206	Хуримтлагдсан элэгдэл	(254,015,594.43)	(310,525,980.02)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,155,727.28	29,508,454.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,065,751.52)	(18,283,551.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,229,061.82	11,229,061.82
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,038,377.57)	(4,063,892.57)
393	Биет бус хөрөнгө	355,240,000.00	354,640,000.00
39301	Программ хангамж	4,200,000.00	4,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,200,000.00)	(1,800,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	352,240,000.00	352,240,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,218,524,829.06</u>	<u>1,472,173,531.40</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>331,496,705.27</u>	<u>347,688,863.05</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	47,895,816.27	347,688,863.05
4136	Бусад өглөг	47,895,816.27	347,688,863.05
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	35,203,723.41	51,480,453.51
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/		14,701,576.52
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	12,692,092.86	281,506,833.02
422	Урт хугацаат зээл	283,600,889.00	-
42217	Санхүүгийн бусад байгууллага	283,600,889.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>887,028,153.79</u>	<u>1,124,484,668.35</u>

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,019,871,781.33	1,303,472,670.33
51101	Өмч: - төрийн	101,167,000.00	101,167,000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	918,704,781.33	1,202,305,670.33
512	Хуримтлагдсан үр дүн	(149,150,904.67)	(195,295,279.11)
51210	Өмнөх үеийн үр дүн	(149,777,086.98)	(149,285,304.67)
51220	Тайлант үеийн үр дүн	626,182.31	(46,009,974.44)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,307,277.13	16,307,277.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,218,524,859.06</u>	<u>1,472,173,531.40</u>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
120	Нийтлэг татварын бус орлого	1,019,855.84	1,743,619.82
120002	Хүүгийн орлого	1,019,855.84	1,743,619.82
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	1,098,889,926.55	1,706,465,046.16
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	811,473,911.21	1,375,022,480.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	287,809,688.87	379,196,160.13
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	284,740,113.06	375,912,554.41
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/		2,625,928.48
210813	Бусад зардал /ТӨҮГ/	3,000,000.00	467,866.66
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	69,575.81	189,810.58
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>626,182.31</u>	<u>(46,009,974.44)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,224,018,263.84</u>	<u>940,723,832.61</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>1,224,018,263.84</u>	<u>940,723,832.61</u>
120009	Бусад орлого	18,636,827.84	2,044,201.82
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	1,204,510,250.00	938,679,630.79
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,090,118,008.38</u>	<u>1,132,081,107.18</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,090,118,008.38</u>	<u>1,132,081,107.18</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>1,090,118,008.38</u>	<u>1,132,081,107.18</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,441,276.34	741,685,621.03
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	382,441,276.34	741,685,621.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,130,512.11	198,155,184.50
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	81,130,512.11	198,155,184.50

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,023,660.52	4,214,053.82
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	15,023,660.52	4,214,053.82
2104	Хангамж, бараа материалын зардал	428,464,244.00	121,804,055.98
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	246,104,500.00	76,016,535.98
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	182,359,744.00	45,787,520.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	183,058,315.41	66,222,191.85
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	65,954,958.62	49,356,011.93
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	1,566,000.00	2,440,430.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	115,537,356.79	14,425,749.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>133,900,255.46</u>	<u>-191,357,274.57</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	50,689,000.00	33,624,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,689,000.00	33,624,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	50,689,000.00	33,624,000.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	00.00	33,624,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(50,689,000.00)</u>	<u>(33,624,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	83,211,255.46	(224,981,274.57)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	177,858,372.37	261,069,627.83
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	261,069,627.83	36,088,353.26

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,019,871,781.33	16,307,277.13	(149,150,904.67)	887,028,153.79
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	16,307,277.13		16,307,277.13
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,019,871,781.33	16,307,277.13	(149,150,904.67)	887,028,153.79
D01	2025 оны 01-р сарын 01-	1,019,871,781.33	16,307,277.13	(149,150,904.67)	887,028,153.79

	нээрх үлдэгдэл				
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	(134,400.00)	(134,400.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	16,307,277.13		16,307,277.13
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	283,600,889.00	00.00	00.00	283,600,889.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(46,009,974.44)	(46,009,974.44)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,303,472,670.33	16,307,277.13	(195,295,279.11)	1,124,484,668.35

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2025оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3,725,163,690.00	1,708,208,665.98	2,016,955,024.02	45.9
	Бүтээгдэхүүний үнийн дүнгээр	3,725,163,690.00	1,708,208,665.98	2,016,955,024.02	45.9
2	Нийт орлого	3,725,163,690.00	1,708,208,665.98	2,016,955,024.02	45.9
	Үүнээс: Улсын чанартай АЗЗА	2,185,740,190.00	1,190,456,280.00	995,283,910.00	54.5
	Ээлжит засвар	1,539,423,500.00		1,539,423,500.00	
	Бусад	-	517,752,385.98	(517,752,385.98)	-
3	Нийт зардал	3,614,865,200.00	1,754,028,830.00	1,860,836,370.00	48.5
	Үүнээс: Удирдлагын үйл ажиллагааны зардал	492,545,000.00	375,912,554.41	116,632,445.59	76.3
4	Татварын өмнөх ашиг	110,298,490.00	(45,820,160.00)	156,118,650.00	-41.5
5	Цэвэр ашиг /алдагдал/	108,673,490.00	(46,009,974.44)	154,683,464.44	-42.3
6	Төсвийн төлбөр, шимтгэл	421,701,320.00	189,225,270.00	232,476,050.00	44.9
	а. Орлогын татвар	1,625,000.00	189810	0.00	-
	б. НӨАТ	193,619,000.00	-	0.00	-
	в. НДШ	114,711,539.00	198,155,184.50	(83,443,645.50)	172.7
	г. Хүн амын орлогын татвар	83,462,480.00	71,727,870.00	11,734,610.00	85.9
	д. Үл хөдлөх хөрөнгө	772,000.00	491930	280,070.00	63.7
	ё. Тээврийн хэрэгсэл	2,695,000.00	1666740	1,028,260.00	61.8
	ж. Бусад татвар	3,000,000.00		3,000,000.00	-

7	Төрийн өмчийн ногдол ашиг	1,080,000.00	-	0.00	-
9	Цалингийн сан	943,078,870.00	870,731,428.70	72,347,441.30	92.3
10	1 ажилтны дундаж цалин	2,535,160.00	2,654,670.00	(119,510.00)	104.7
11	Борлуулалтын нэг төгрөгт ноогдох зардал	1.00	1	0.00	100.0
12	Хөрөнгө оруулалт	59,330,000.00	33,624,000.00	25,706,000.00	56.7
13	Нийт авлага	8,500,000.00	559,461,269.60	(550,961,269.60)	6,581.9
14	Нийт өглөг	291,600,900.00	348,555,033.05	(56,954,133.05)	119.53
	Үүнээс: богино хугацаат	8,000,000.00	348,555,033.05	(340,555,033.05)	4,356.9 4
	Урт хугацаат өглөг /Кувейтын сан/	283,600,889.00	0.00	283,600,889.00	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3 Залруулагдаагүй нийт 600.0 мянган төгрөгийн зөрчил тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 3 зөрчил¹ илэрч, 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2 зөвлөмж хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

2. Салбарын менежер тушаал шийдвэр гаргаж 600.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт авсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", Авто зам засвар, арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны Б/03 дугаар тушаалтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Олгосон 600.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлого болгох.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг: Хууль тогтоомжтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайланд онд татаас санхүүжилтийн 485,590.8 мянган төгрөгийн, НӨАТ-ын 64,574.0 мянган төгрөгийн, бусад 9,217.5 мянган төгрөгийн авлага, дээд газартай тооцоо нийлсэн бараа материалын 255,546.1 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 51,178.7 мянган төгрөг, НДШ-ийн 14,701.5 мянган төгрөгийн, тэтгэмжийн 18,480.0 мянган төгрөгийн, бусад 7,782.5 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх", Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн гүйцэтгэл захирлын 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн дугаар А/85 "Говь-Алтай аймаг дахь салбарын 2025 оны орлого зардлын төлөвлөгөөг батлах тухай" тушаалын 2- "Батлагдсан төлөвлөгөөг үзүүлэлт тус бүрээр хангаж ажиллах, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр авлага барагдуулах талаар шаардлагатай арга хэмжээ авч, худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд тусгасан өр, авлагыг барагдуулж, ажиллах.

Илрүүлэлт: Тайлант онд 46,009.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", "Авто зам засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК-ийн гүйцэтгэл захирлын 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/85 "Говь-Алтай аймаг дахь салбарын 2025 оны орлого зардлын төлөвлөгөөг батлах тухай" тушаалын 2-т "Батлагдсан төлөвлөгөөг үзүүлэлт тус бүрээр хангаж ажиллах, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр авлага барагдуулах талаар шаардлагатай арга хэмжээ авч, худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Судалгаа, тооцооллыг үндэслэлтэй хийж алдагдалгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
“Авто зам засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн Говь-Алтай аймаг дахь салбар	Салбарын менежер өөртөө тушаал шийдвэр гаргаж 600.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт авсан.	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-
	Тайлант онд 46,009.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан.	1	-	-	-	-	-	1	-	-	-
	Тайланд онд татаас санхүүжилтийн 485,590.8 мянган төгрөгийн, нэмэгдсэн өртгийн албан татварын 64,574.0 мянган төгрөгийн, бусад 9,217.5 мянган төгрөгийн авлага, дээд газартай тооцоо нийлсэн бараа материалын 255,546.1 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 51,178.7 мянган төгрөг, НДШ 14,701.5 мянган төгрөгийн, тэтгэмж 18,480.0 мянган төгрөгийн, бусад 7,782.5 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн.	1	-	-	-	-	-	-	1	-	-
Нийт		3	600.0	1	600.0	-	-	2	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалт тай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			